



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



Empowered lives
Resilient nations

“БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН МЕНЕЖМЕНТ БҮХИЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР
НУТГИЙН СҮЛЖЭЭ” МОН/13/303 ТӨСӨЛ

“ТҮМЭНХААН-ШАЛЗ”

ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР

ТАЛ ХЭЭРИЙН БҮСЭД НУТГИЙН
ИРГЭДЭД ТҮШИГЛЭСЭН БАЙГАЛИЙН
НӨӨЦИЙН МЕНЕЖМЕНТИЙН ЗАГВАР




“ТҮМЭНХААН-ШАЛЗ” ОНХГ

ТАЛ ХЭЭРИЙН БҮСЭД НУТГИЙН ИРГЭДЭД ТҮШИГЛЭСЭН
БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН МЕНЕЖМЕНТИЙН ЗАГВАР

ОНХГ-т авсан зорилго:

- Байгаль орчин, аялал жуулчлалын яам, НҮБХХ-ийн “Байгалийн нөөцийн менежмент бүхий хамгаалалттай газар нутгийн сүлжээ” төслийн хүрээнд орон нутгийн захиргаа, иргэдийн санаачилгаар Тосонхулстай, Онон Балжийн Улсын тусгай хамгаалалттай газруудын хооронд орших 374,499 га талбай бүхий газар нутгийг Дагуурын ойт хээр, цагаан зээр, монгол тарвага, нүүдлийн шувуудад чухал газруудыг хамгаалах зорилгоор 2013 онд доорх 3-н сум тус тусын ИТХ-ын шийдвэрээр орон нутгийн тусгай хамгаалалтад авсан бөгөөд дараахь байдлаар баталгаажсан. Үүнд:
 - **“Дун хаан-Шалз”** ОНХГ-ыг Дорнод аймгийн Баян-Уул сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны 12-р сарын 15-ны өдрийн 07 дугаар тогтоол
 - **“Тосон хулстай”** ОНХГ-ыг Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны 12-р сарын 26-ны 07 дугаар тогтоол
 - **“Түмэнхаан-Могойн шил”** ОНХГ-ыг Хэнтий аймгийн Норовлин сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны 12-р сарын 16-ны 05 дугаар тогтоол
- Дээрх 3 ОНХГ-ыг хамтад нь “Түмэн хаан-Шалз” гэж нэрлэхээр гурван сумын төлөөлөгчдийн оролцсон 2014 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн нэгдсэн хурлын шийдвэрээр тогтсон юм.




ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ГАРСАН АМЖИЛТ, ҮР ДҮН:




Нутгийн иргэдэд түшиглэсэн менежментийн бүтэц, зохион байгуулалт бий болсон:

“ТҮМЭНХААН-ШАЛЗ” ОНХГ-ын менежментийн бүтэц



- Менежментэд оролцогч талуудын 11 төлөөлөл (2 аймгийн БОАЖГ, 3 сумын ЗД, байгаль хамгаалагч, УТХГ-ын 2 хамгаалалтын захиргаа)-өөс бүрдсэн ОНХГ-ын Хамтын менежментийн зөвлөл нь менежментийн болон бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг удирдлагаар хангах, санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх, менежментийг хариуцагчид дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.
- Сум тус бүрт ОНХГ-ын хамгаалалтыг хариуцсан Байгаль хамгаалагчийн орон тоог шинээр бий болгосноор нөхөрлөлүүдийг идэвхжүүлэн сумын байгаль орчны тасагтай хамтран ОНХГ-ын менежментийг хэрэгжүүлэх боломжийг олгож байв. Төсөл дуусахад Дорнод аймгийн Баян-уул суманд тус орон тоог авч үлдсэн ба Цагаан-овоо, Норовлинд БОУБ, бусад байгаль хамгаалагч нарын ажил үүргийн хувиарт оруулан тогтвортой байдлыг хангахаар төлөвлөж байна.





- Тухайн хамгаалалттай газрын нутаг дэвсгэрт цагаан зээр, тарвага болон нүүдлийн шувуудын амьдрах орчин, тархац нутгийг хариуцан хамгаалах **15-н байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл /149 өрх, 495 гишүүн/** нутгийн иргэдийн санал санаачлага дээр тулгуурлан үүсгэн байгуулагдаж нийт 316,8 мян га газар нутгийг сумдын Засаг даргатай байгуулсан гэрээний үндсэн дээр хариуцан хамгаалж байна.
- Нийт **30 Идэвхтэн байгаль хамгаалагч** хариуцан хамгаалж буй газар нутагтаа зэрлэг амьтны мониторинг, эргүүл хяналтийг хийж байна.
- ОНХГ-ын гурван сум, зэргэлдээ орших Дорнодын УТХГ-ын ХЗ, Онон Балжийн БЦГ-ын ХЗ-тай хамтын ажиллагааны **Санамж бичиг** байгуулж идэвхтэн байгаль хамгаалагчдийн чадавхийг бэхжүүлэх, хамтарсан мониторинг, судалгаа, эргүүл хяналт хийх, мэдээллийн сан бүрдүүлэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлж байна.



Боловсруулан хэрэгжүүлж буй баримт бичгүүд:

- Түмэнхаан-Шалз ОНХГ-ын урт хугацааны стратеги (2015-2025)
- ОНХГ-ын менежментийн төлөвлөгөө (2015-2018)
- ОНХГ-ын Бизнес төлөвлөгөө (2015-2018) тус тус боловсруулагдан сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар батлагдан хэрэгжиж байна.
- Хамгаалалтын менежментийг хэрэгжүүлэх зорилгоор ОНХГ-ын горимыг боловсруулан сумын ИТХ хэлэлцэн баталсан.
- Газрын орон нутгийн хамгаалалтад авах, хилийн цэсийг өргөтгөх, менежментийн төлөвлөгөөг батлах, ховор, ховордсон шувуудын амьдрах орчныг хамгаалах талаар сумын, БИНХ-ын тогтоол шийдвэрүүдийг батлан хэрэгжүүлж байна.
- Нөхөрлөл тус бүр өөрийн дүрэм, гишүүнчлэлийн журам, удирдах болон хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм, дундын эргэлтийн сангийн журам зэргийг бүх гишүүдийн хурлаараа баталгаажуулан үйл ажиллагаандаа удирдлага болгон ажиллаж байна.



ОНХГ-ын менежментийн үр ашигт байдал нэмэгдсэн:

- Анх үүсгэн байгуулагдснаас хойш Түмэнхаан-Шалз ОНХГ-ын менежментийн үр ашигт байдал **90%**-р өсч оноо нь 2013 онтой харьцуулахад **4-с 67-д** хүрсэн ба 2017 оны сүүлчээр менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт **72%**-тай байна.



Түлхүүр зүйлийн амьдрах орчин сайжирсан:

- Хамгаалалттай газар нутагт амьдарч буй малчдын малын бэлчээр цагаан зээрийн (*Procapra gutturosa*) бэлчээрлэлтийн давхцал улам ихсэж, тус нутагт цагаан зээрийн бэлчээрлэх хугацаа илүү болсон (*нөхөрлөлийн малчдын аман мэдээгээр*)
- Тус төсөл болон “Экосистемд түшиглэсэн дасан зохицох арга хэмжээг уур амьсгалын өөрчлөлтөнд өндөр эрсдэлтэй голуудын сав газарт хэрэгжүүлэх нь” төслийн санхүүжилтээр 2016 онд ШУА-ийн Ерөнхий болон биологийн хүрээлэн гүйцэтэж Баян-уул, Цагаан-овоо суманд “Хараат”, “Өвөрхоолой”-н нөхөрлөлийн бэлчээрт 23 бүлийн 117 бодьгалыг сонгож сэргээн нутагшуулж тус нөхөрлөлүүдэд хариуцуулан өгч мониторингийн арга зүйг зааж өгсөн юм. Байгаль хамгаалагч нарын хатуу хяналт, сумын засаг захиргааны дэмжлэг, нөхөрлөлийн бүх гишүүдийн хамгаалалтын үр дүнд 2 жилийн хугацаанд тарвагны тоо толгой, бүлийн тоо эрс өсч, нутагшил газар нь тэлж нэмэгдсэн (*нутгийн иргэд, сумын удирдлага, албан хаагчдын мэдээ, Идэвхтэн байгаль хамгаалагчдын тэмдэглэл*)



Менежментэд оролцогч талуудын идэвх санаачилга эрс дээшилсэн:

- Нөхөрлөлүүдийн байгаль хамгаалах санаачлагыг хөхүүлэн дэмжих, орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилгоор нийт 26,3 сая төгрөгийн 6 жижиг төслийг хэрэгжүүлсэн. Үүнээс 14,7 сая төгрөгийг төслөөс, 11,6 сая төгрөгийг байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлөөс /өөрсдийн хөдөлмөр болон бусад зардал/ санхүүжүүлсэн юм. Үүний үр дүнд Норовлин сумын Хөх Асган (хүнсний ногоо), Баян-уул сумын Улаан-өндөр (тахиа), Хараатын гол (цагаан идээ) зэрэг нөхөрлөлүүдийн орлого 20-38%-р нэмэгдсэн. Баян-уул сумын Эрдэнэбулаг нөхөрлөл жижиг төслөөр авсан 2 бүл зөгийг өсгөж 10 бүл болгон нэмэгдүүлж 2 жилийн хугацаанд ашиг орлого нь 117%-р өссөн;
- 2016-2017 онд сумдын ЗДТГ-тай хамтран нөхөрлөл, идэвхтэн байгаль хамгаалагч нарын дунд уралдаан зарласан ба нөхөрлөлийн эхний 3 байр нийт 4,1 сая төгрөг, шилдэг 3 идэвхтэн байгаль хамгаалагч 5,1 сая төгрөгний үнэ бүхий шагнал тус тус хүртэж, нөхөрлөлүүдийн үйл ажиллагаа эрс идэвхжиж, идэвхтэн байгаль хамгаалагч нарын мэдлэг, ур чадвар дээшилсэн.





- Тус ОНХГ-ын хилийн тэмдэгжүүлэлт (14,0 сая төгрөгийн өртөг бүхий 13 ширхэг мэдээллийн самбар, 30 ширхэг хилийн багана, 12 ширхэг хориглох тэмдэг)-ийг Монгол улсын стандарт-MNS5851: 2008-ын дагуу үйлдвэрлүүлж, тогтоосон цэгүүдэд байршуулсан;

- Норовлин, Баян-уул, Цагаан-овоо суманд “Орон нутгийн тусгай хамгаалалттай газрын менежментийг дэмжигч эко-сургууль” бий болсноор малчдын хүүхдийн хамгаалалттай газар нутгийн талаарх мэдлэг дээшилж, сургуулийн хичээлүүдийн сэдэвт биологийн олон янз байдлын сэдвийн интеграци хийгдсэн.

- Баян-Уул сумын төвд 2016 онд байгаль хамгаалагч нарын хяналт шалгалтын үр дүнд хураагдсан 120 гаруй хавхыг ашиглан тарвагны хөшөө босгон байрлуулж тус сум нь “Хавхгүй сум” болох зорилго тавиад байна.
- Байгалийн нөөцийн хамтын менежмент, хууль эрх зүй, байгаль орчны төлөвлөлт, санхүүжилт, зэрлэг амьтны мониторинг судалгааны арга зүйн хээрийн болон

танхимын сургалт, нөхөрлөл хөгжлийн наадам, туршлага судлах аялал зэрэг арга хэмжээг шат дараатай зохион байгуулж давхардсан тоогоор нийт **1200** орчим хүн хамрагдсан.

- Норовлин сумын ЗДТГ-т 11,9 сая төг, Цагаан-овоо суманд 11,9 сая төг, Баян-уул суманд 13,0 сая төг, Дорнод аймгийн БОАЖГ-т 4,9 сая төг, Дорнод аймгийн ГХБХБГ-т 6,0 сая төг, Хэнтий аймгийн БОАЖГ-т 4,9 сая төг, Хэнтий аймгийн ГХБХБГ-т 6,0 сая төгрөг нийт 59,0 сая төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж, техник хэрэгсэл тус тус олгосноор ОНХГ-ын хамгаалалтын менежментэд оролцогч талуудын чадавхи бэхжиж, ажиллах нөхцөл сайжирсан.
- Идэвхтэн байгаль хамгаалагч нар хамгаалалтын техник хэрэгсэл, хувцас зэргийн хангалт: 70-аас дээш хувь нь гар GPS, 30 хувь нь дуран, зургийн аппарат, 25 хувь нь мотоциклтэй
- Эдгээр 3 суманд гарсан **түймрийн тоо** 2015-2016 онд **40%**-иар, 2016-2017 онд **80%**-иар, **хулгайн ан** 2015-2016 онд **15%**-иар, 2016-2017 онд **30%**-иар буурсан явдалд нөхөрлөл, идэвхтэн байгаль хамгаалагчдын хувь нэмэр багагүй байсан.
- ОНХГ-ын зарим нөхөрлөл “Тогтвортой ноос, ноолуурын эвсэл” олон улсын ТББ-тай хамтарч ажиллах сертификат хүлээн авч “тогтвортой” ноолуур ханган нийлүүлэх чадамжтай болохоор зорьж байна.



ОНХГ-ын тогтвортой санхүүжилтийг бүрдүүлэх:

- НҮБХХ-ийн БИОФИН төслийн хүрээнд Түмэнхаан-шалз ОНХГ-т тогтвортой санхүүжилтийн боломжит хувилбар болох махны өртгийн сүлжээний зардал, үр ашгийн тооцоог батгаасан бизнес төлөвлөгөөг боловсруулан, түүнийг хэрэгжүүлэх механизмыг тодорхойлох, хөрөнгө оруулагчдыг татах үйл ажиллагааг эхлүүлээд байна.
- Төслийн хүрээнд бий болсон чадавхи, гарсан үр дүнг цаашид тогтвортой авч явах, бэлчээр, зэрлэг амьтныг цогцоор нь хамгаалах хүрээнд тус төсөл, ШХА-

ийн Ногоон Алт хөтөлбөр, сумын малчид гурван талаас ижил хэмжээний мөнгөн дүнг нийлүүлж 3 суманд **“Бэлчээр ашиглалтын хэсгийн дундын мөнгөн хуримтлалын сан”** байгуулав. Үүнд: Хэнтий аймгийн Норовлин суманд **15,8 сая төг**, Дорнод аймгийн Баян-уул суманд **35,8 сая төг**, Цагаан-овоо суманд **25,9 сая төг**. төвлөрсөн. Тус сангаас малчдын байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг санхүүжүүлэх, гишүүн өрхүүдэд жижиг зээл олгохоос гадна Идэвхтэн байгаль хамгаалагч нарын мониторинг, эргүүл хяналт хийх шатахууны зардал, урамшууллыг шийдвэрлэх юм.



Түмэнхаан-Шалз ОНХГ-т төсөл хэрэгжүүлснээр гарсан **ТЭРГҮҮН ТУРШЛАГА**

- Экологийн чухал ач холбогдол бүхий томоохон хэмжээний газар нутгийг орон нутгийн хамгаалалтад авах замаар нутгийн иргэдийн оролцоотой хамгаалах нь тухайн нутагт буй зэрлэг амьтны амьдрах орчныг сайжруулах, улмаар бэлчээр, байгалийн нөөцийг нөхөн сэргээхэд чухал үр нөлөөтэй.
- Түмэнхаан-Шалз ОНХГ-ын хамгаалалтын менежментийг зэргэлдээ орших 2 улсын ТХГ-ын хамгаалалтын захиргаатай (Дорнодын УТХГ, Онон Балжийн БЦГ) хамтран хэрэгжүүлж байгаа энэхүү шийдэл нь том хэмжээний газар нутгийн хамгаалалтын менежментийг үр ашигтай хангах хамтын ажиллагааны шинэлэг арга хэлбэр болж байгаа юм.
- Цагаан зээрийн нүүдлийн **экологийн коридор** нутгийг зүүн бүсэд Монголд анх удаа үүсгэн байгуулж **407,3 мян га** нутгийг орон нутгийн тусгай хамгаалалтад авсан.



Түмэнхаан-Шалз ОНХГ-т төсөл хэрэгжүүлснээр гарсан **СУРГАМЖ**

- ОНХГ-ын хамгаалалтын менежментийг сум өөрөө хэрэгжүүлэх боломжтой. Энэ тохиолдолд суманд тухайлсан байгаль хамгаалагчийн орон тоог бий болгох зайлшгүй шаардлагатай. Ингэснээр тухайн орон тоог байлгах зардлаас хэд дахин илүү хамгаалалтын арга хэмжээний зардлыг хэмнэх боломжтой юм. Тус байгаль хамгаалагчийн үүрэгт байгаль хамгаалах арга хэмжээнээс гадна менежмент, зохион байгуулалтын мэдлэг, чадвар чухал.
- ОНХГ нь 2-оос дээш аймаг, сумын нутгийг дамнан оршиж буй тохиолдолд тус ОНХГ-ын Хамтын менежментийн зөвлөл байгуулж, талуудын оролцоог хангаж ажиллах, менежментийн төлөвлөгөөг хамтран хэрэгжүүлэх, санхүүжилтийг аймаг, сумын байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос хуваарилах
- ОНХГ-ын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт, төлөвлөгөөнд тодорхойлсон зорилт, шалгуур үзүүлэлтүүдийг хангаж буй эсэхэд хамтын оролцооны аргаар 2 жилд нэг удаа үнэлгээ хийх ("Хамгаалалттай газар нутгийн менежментийн үр ашигт байдлын үнэлгээ" МОН-МЕТТ аргаар). Үүнд:
 - ОНХГ-ын үнэт зүйлс, экосистем, биологийн олон янз байдлын төлөв байдлыг суурь нөхцлөлтэй харьцуулах, сайжруулах, биологийн төрөл зүйлд учирч байгаа аюул заналыг бууруулах талаар авсан арга хэмжээ г.м.)
- Үнэлгээний үр дүнг нөхөрлөлийн гишүүдэд БИНХ-аар дамжуулан танилцуулах, аймаг, сумын ИТХ-аар хэлэлцүүлэн менежментийн үр ашгийг сайжруулах талаар чиглэл, зөвлөмж, шаардлагатай бол тогтоол, шийдвэр гаргуулах.

“ТҮМЭНХААН-ШАЛЗ ” ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР



НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр - www.undp.mn

Байгаль орчин, аялал жуулчлалын яам

Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газар - www.mpa.gov.mn